

Газар хэмжүүлэх хүсэлт гаргасан 6 иргэний өргөдлийг хүлээн авч 100220029002 тоот дансанд 150000 төгрөгийг төвлөрүүлж, 3 иргэний газарт эргэлтийн цэгийг суулгаж бэхэлсэн.

Мөн газар барьцаалах үйлчилгээг 27 иргэн, аж ахуйн нэгжийн газарт хийж 270000 төгрөгийг Сүмбэр сумын тэмдэгтийн хураамжийн 100220500941 тоот дансанд төвлөрүүлэн ажиллаад байна.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

“Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” хууль болон холбогдох дүрэм журам батлагдан мөрдөгдөж байгаатай холбогдуулан Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих зэрэг төслийн хүрээнд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1, 2 дугаар багийн оршин суугчдын амьдрах орчин нөхцлийг сайжруулах, хөрсний бохирдлыг багасгах шаардлагатай нөхцөл байдал үүссэн 4 байршлыг сонгож санал солилцох, газар дээр нь үзэх, дээрхи төслүүдийн талаар мэдээлэл зөвөлгөө авах зорилгоор БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Э.Дондмаа болон холбогдох мэргэжилтэнгүүд, ГЗБГЗЗГ-ын хот төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Болормаа, “Монгол Улсын хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дахь үе шатны төслийн багийн бүрэлдэхүүнтэй аймгийн Засаг дарга болон холбогдох хэлтэс агентлагуудтай хамтран санал солилцон хамтран ажиллаа. Цаашид дахин төлөвлөлт хийх шаардлагатай газрын судалгаа мэдээллийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу нарийвчлан хийж, шаардагдах хөрөнгө санхүүжилттай холбогдолтой асуудлыг урьдчилан төлөвлөн шийдвэрлэх, нийслэл хотод хэрэгжүүлж буй дахин төлөвлөлтийн ажилтай танилцах, туршлага судлах зэрэг олон асуудлыг талаар санал солилцсон.

Дээрхи ажлын хүрээнд сонгосон байршлуудад судалгааны ажлыг эхлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2017 оны үр дүнгийн гэрээнд тусгагдсан дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- 1-д заасны дагуу барилгын материалын сорил шинжилгээний лабораторын барилгын асуудлыг шийдвэрлэхээр барилгын зураг төслийг боловсруулах ажил хийгдэж 80% байна.
- 4-д заасан заалтын дагуу 2017.03.16-ны өдрийн А/78 дугаар Засаг даргын захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж Сүмбэр сумын 3-р багийн нийтийн эзэмшлийн орон сууцны барилгуудын дээвэр, дээврийн адрын хөндий, агааржуулалт, хана, суурь, техникийн давхар, үндсэн бүтээцийн элэгдэл, эвдрэл гэмтэлд үзлэг шалгалт хийх ажлыг 2017.04.11-14-ний өдрүүдэд нийт 6 үзүүлэлтээр 10 байранд үзлэг шалгалтыг хийсэн.
- 9-д заасны дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх ашиглалтад оруулах дүрмийн дагуу дараах ажлуудад ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон байна. Үүнд:
 1. Сүмбэр сумын 3-р баг, 5-р сургуулийн дотуур байрны засварын ажил
 2. Баянтал сумын 4-р сургуулийн Спорт залны цахилгаан хангамжийн ажил
- 12-д заасны дагуу Үндэсний хөтөлбөрүүдийн тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилллаж байна.
- 27-д заасны дагуу Шивээговь сумын 1-р багийн иргэн П.Мөнхжаргалын худалдаа, үйлчилгээний зориулалттай барилгын ажлийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулан, баталгаажуулсан байна.
- 31-д заасны дагуу “Эко-Сүмбэр” хотхоны ашиглалтад орсон барилга байгууламжийн гадна тохижилтийн ажлыг хийж гүйцэтгэх, барилгын гадна өнгө үзэмжийг сайжруулах зэрэг албан шаардлагыг гүйцэтгэгч “Хүрийн хотхон” ХХК-д хүргүүлээд байна. Мөн хувийн хэвлийн хөрөнгө оруулалтаар барилгын ажил гүйцэтгэж буй компаниудтай уулзалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- Мөн орон сууцны эрэлт хэрэгцээг тодорхойлох зорилгоор саналыг боловсруулан иргэдээс судалгааг авч ажиллаж байна.

Тайлан мэдээ:

- АЗДТГазарт үйл ажиллагааны төлөвлөгөөний 1 дүгээр улирлын тайланг гарган хүргүүлсэн.
- БХТөвд орон сууцны барилгын үнэ, борлуулалтын мэдээг хүргүүлсэн.
- Аймгийн Аудитийн газарт 2014-2016 оны улсын төсвөөр хийгдсэн ажлуудын тайлан мэдээг маягтын дагуу гаргаж хүргүүлсэн.


Захиалагчийн хяналтын чиглэлээр:

Ерөнхий захиалагчийг төлөөлөн дараах ажлуудад захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна: Үүнд:


1. Сүмбэр сум, 3-р баг, 5 дугаар сургуулийн дотуур байрны барилгын засварын 65-70% гүйцэтгэлтэй байна. Захиалагч: АЗДТГ, Гүйцэтгэгчээр: "ГЭЭТ" ХХК,



Баянтал сумын 4 дүгээр сургуулийн дотуур байрны засварын ажлын гүйцэтгэл 85-90%-тай гүйцэтгэж байна. Захиалагч: Баянтал сумын ЗДТГ, Гүйцэтгэгч: “Харвайн толгой” ХХК



Баянтал сумын 4 дүгээр сургуулийн спорт заалны дотор цахилгаан монтаж угсралтын ажил 65-70%-н гүйцэтгэлтэй байна. Захиалагч: Баянтал сумын ЗДТГ, Гүйцэтгэгч: “Энхжих формат” ХХК



- Дараах объектуудад ажлын гүйцэтгэл баталгаажуулсан байна. Үүнд:
 - 1.Баянтал сумын дотуур байрны засварын ажил - 34,903,976 төгрөг – Ажлын 70%
 2. Баянтал сумын 4-р сургуулийн спорт залны цахилгаан монтаж угсралтын ажил - 6,616,000 – Ажлын 70%